

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.11.26-11.30

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. S&P 500 индекс 2011 оны 12-р сараас хойшхи хамгийн өндөр өсөлтийг үзүүлээ. Тус индексийн сагсанд багтдаг эрүүл мэнд болон мэдээлэл технологийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш хамгийн ихээр өссөн бол түүхий эдийн салбарын компаниудын хувьцааны ханш хамгийн ихээр буурчээ. АНУ-ын дотоодын газрын тосны ханш унаж, 50 ам.доллараас бага түвшинд хүрсэн тул эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш буурсан үзүүлэлттэй байна.

“Хар баасан гараг” тохиосонтой холбогдуулан Лхагва гарагаас Баасан гарагийн хугацаанд интернет худалдаа өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 26.4%-аар өсчээ.

Мягмар гарагт АНУ-ын Ерөнхийлөгч БНХАУ-ын импортын бараа бүтээгдэхүүнд ногдуулсан 10%-ийн татвараа 2019 оны эхэн үеэр 25% болгон нэмэх талаар мэдээлж, хөрөнгийн зах зээлийн индексүүд унаж эхэлсэн билээ.

Холбооны Нөөцийн банк 12-р сард бодлогын хүүгээ нэмэгдүүлэх шийдвэр гаргаж магадгүй байна. Үүний дараа бодлогын хүүг алгуур өсгөх талд илүү уян хатан бодлого хэрэгжүүлэхээр болж байгаагаа тус банкны бодлого тодорхойлогчид илэрхийллээ.

АНУ-ын Худалдааны яамны мэдээлснээр 10-р сард орон байрны худалдаа 9 орчим хувиар буурч, сүүлийн 2 жил хагасын хугацаан дахь хамгийн доод түвшинд хүрчээ. Ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдөл гаргагчдийн тоо 4 сар дараалан буурсан бол орон нутгийн аж үйлдвэрийн индекс таамагласан хэмжээнд хүрч чадаагүй байна. Мөн 10-р сард хувь хүний орлого, хэрэглээний түвшин таамагласан түвшнээс ихээр өсчээ.

Европ: “Их-20” орнуудын уулзалт, “Brexit” хэлэлцээрийг тойрсон асуудалтай холбоотойгоор Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд бага хэмжээний өсөлт үзүүллээ.

Их Британийн Ерөнхий сайд хатагтай Тереза Мэйн Засгийн газрын боловсруулсан “Brexit” хэлэлцээрийн төслийг Европын Холбооны удирдагчид баталлаа. Харин одоо Их Британийн Парламент тус хэлэлцээрийг 12-р сарын 11-ны өдөр батлах шаардлагатай аж. Их Британийн Ерөнхий сайд хатагтай Тереза Мэй Парламентын нийт 650 гишүүний 320-ынх нь дэмжлэгийг авах шаардлагатай байгаа юм.

Английн төв банк Их Британи ямар нэгэн хэлэлцээрт хүрэлгүй Европын холбооноос гарвал тус улсын аж ахуйн нэгжүүд хамгийн ихээр хохирох болохыг онцоллоо.

Япон: Японы хөрөнгийн зах зээлийн Nikkei 225 индекс 5 өдөр дараалан өслөө.

Япон улсын Ерөнхий сайд Шинзо Абэ 2019 оны 10-р сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэглээний татварыг 8%-аас 10% болгон өсгөх талаар мэдээлэв.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,514.19	-0.40% ▼
Dow Jones	АНУ	25,538.46	5.16% ▲
S&P 500	АНУ	2,760.17	4.85% ▲
Nasdaq	АНУ	7,330.54	5.64% ▲
S&P/TSX	Канад	15,197.82	1.25% ▲
FTSE 100	Их Британи	6,980.24	0.39% ▲
S&P/ASX 200	Австрали	5,667.20	-0.86% ▼
Nikkei 225	Япон	22,351.06	3.25% ▲
Hang Seng	Хонг Конг	26,506.75	2.23% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	106.00
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	93.93
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	93.02
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	109.64
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.65
DBM' 2023	USD	7.250%	97.64
TDBM' 2020	USD	9.375%	104.08

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.347	0.03 ▲
Libor 3M	2.736	0.04 ▲
Libor 6M	2.895	0.01 ▲
Libor 1YR	3.120	0.00 ▼
US 2YR Bond	2.833	0.01 ▲
US 3YR Bond	2.855	0.01 ▲
US 5YR Bond	2.872	-0.01 ▼
US 10YR Bond	3.035	-0.01 ▼

Валютын ханш /төг/

Валют	2018.11.30	Өөрчлөлт
USD	2,627.04	1.16% ▲
CNY	378.32	1.13% ▲
EUR	2,988.26	0.83% ▲
RUB	39.46	-0.35% ▼
KRW	2.34	2.18% ▲
JPY	23.15	0.61% ▲
CAD	1,975.44	0.40% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,224.26	0.10% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	14.29	0.00% -
Зэс	USD/lb.	284.25	2.05% ▲
Нүүрс	USD/MT	101.60	4.72% ▲
WTI газрын тос	USD/bbl.	53.70	6.51% ▲
Brent газрын тос	USD/bbl.	62.33	6.00% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	4.49	4.18% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. X	6.30%
Бодлогын хүү	2018. XI	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. X	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. X	12.30%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. X	5.40%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. X	17.40%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. X	10.70%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 41 компанийн 659.8 сая төгрөгийн 4,304,843 ширхэг хувьцаа арилжигдав.


“Алтайн зам” /AZH/ компанийн хувьцаа 51.64%-аар буюу хамгийн ихээр өсч 60,200 төгрөгт хүрч хаагдсан бол “Орхондалай” /ORD/ компанийн хувьцаа 32.68%-аар буурч 2,400 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны зах зээл дээр нийт 160 ширхэг үнэт цаас 16.2 сая төгрөгөөр арилжаалагджээ.

11-р сарын 30-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,303.0 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,514.19 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.40%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	676.0
Зах зээлийн үнэлгээ	2,302,979.5

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,514.19	-0.40% ▼
MSE I индекс	9,271.33	0.08% ▲
MSE II индекс	8,455.44	2.07% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
ЛэндМН ББСБ	2,446,002	171,405,799
Ард даатгал	150,983	112,116,312
Хөвсгөл алтан дуулга	118,07	98,907,882
Жинст-Увс	45,886	76,572,022
Говь	1,832	59,370,960

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Алтайн зам	60,200.00	51.64% ▲
Жинст-Увс	1,783.00	33.66% ▲
Багануур	1,679.00	15.00% ▲
Могойн гол	6,405.00	14.27% ▲
Хөвсгөл алтан дуулга	920.00	12.33% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Орхондалай	2,400.00	-32.68% ▼
Монинжбар	90.00	-18.18% ▼
Дархан зочид буудал	90.00	-14.29% ▼
Тав	6,405.00	-12.21% ▼
Гутал	920.00	-5.56% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Мирэ Эссет Секьюритис Монгол	337,221,823
Ард секьюритиз	259,139,726
Бумбат-Алтай	138,753,982
Би Ди Сек	138,466,169
Стандарт инвестмент	106,222,315

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	572.00	608,712
Таван толгой	6,500.00	342,324
Говь	33,000.00	257,437
МИК	10,350.00	214,341
Сүү	227.10	78,122

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-14/02/19-A0208-18	83	8,515,800	102,600	102,600	104	18.000%
2	ZGEB-BD-14/02/19-A0208-18	77	7,700,000	100,000	100,000	104	18.000%

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.08.31	2018.09.10	2018.10.10-нд олгов
2	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
3	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
4	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов
5	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с
6	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов
7	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
8	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор
9	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
10	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
11	SUL	Жуулчин дюты фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
12	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
13	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
14	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов
15	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
16	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов
17	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор
18	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов
19	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов
20	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
21	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
22	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	2018.03.06	2018.09.21-нд олгов
23	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов
24	TAH	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
25	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с
26	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов
27	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Эрдэнэт Зандан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Эрдэнэт зандан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 01 тоот шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдөр зарлан хуралдуулахаар боллоо.

Хувьцаа эзэмшигчдийн хуралдах хугацаа: 2018.12.12-ны өдрийн 10:00 цагт

Бүртгэх өдөр: 2018.11.27-ны өдөр

Хуралдах газар: Орхон аймаг, Говил баг, Эрдэнэт Зандах ХК-ийн үйлдвэрийн байр

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. “Эрдэнэт Зандан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгож, Төлөөлөн удирдах зөвлөлийг шинээр байгуулах тухай;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын, Цалин урамшууллын, Нэр дэвшүүлэх хороодыг байгуулах тухай; ТУЗ-ийн дэргэдэх хороодод гишүүдийг томилох тухай;
3. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх гүйцэтгэх удирдлагын дүгнэлт бүхий тайлан;
4. Компанийг өөрчлөн байгуулах төсөл;
5. Хараат бус үнэлгээний байгууллагаар хийлгэсэн компанийн бизнесийн үнэлгээ;
6. Нэгж хувьцааг эргүүлэн авах үнэ;
7. “Эрдэнэт зандан” ХК-ийн дүрмийн төсөл;
8. Компанийг өөрчлөн байгуулахтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх журам.

Дэлгэрэнгүй мэдээллийг: 9901-1106.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Говь” ХК-ийн хувьцааг хувааж, зарим компанид тусгай зөвшөөрөл олголоо

Санхүүгийн зохицуулах хорооны ээлжит хуралдаан 11-р сарын 30-ны өдөр боллоо.

Холбогдох хууль, журмын дагуу тогтоол гаргаж, “Говь” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 7,801,125 (долоон сая найман зуун нэг мянга нэг зуун хорин таван) ширхэг хувьцааг 100 хувааж, нэг бүр нь 1 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 780,112,500 (долоон зуун наян сая нэг зуун арван хоёр мянга таван зуун) ширхэг энгийн хувьцаа болгон хуваахаар шийдвэрлэлээ. Ингэснээр хувьцааны хөрвөх чадвар, хувьцаа эзэмшигчдийн тоог нэмэгдүүлэх, компанийн зах зээлийн үнэлгээг өсгөх, цаашлаад хувьцааны төвлөрлийг бууруулах ач холбогдолтой юм. Иймд хувьцаа хуваах үйл ажиллагааг ажлын 10 хоногийн дотор багтаан гүйцэтгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК, “Үнэт цаасны цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д тус тус үүрэг болголоо.

Хуралдаанаар, “Тээвэр хөгжлийн банк” ХХК-д үнэт цаасны зах зээлд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олголоо. Ингэснээр тус зах зээлд андеррайтерийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо 25 болж буй юм.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо



“Парк таун” бондын захиалга 12-р сарын 3-ны өдөр өндөрлөнө

Үнэт цаасны зах зээлд анх удаагаа орон нутгаас буюу Дархан-Уул аймгаас барилгын “Минж Проперти” компани нэг тэрбум төгрөгийн үнийн дүнтэй “Парк таун” бондыг олон нийтэд гаргаад байгаа билээ.

Тус компанийн санал болгож буй бондын жилийн хүү нь банкны хадгаламж болон үнэт цаасны хүүгээс хамаагүй өндөр бөгөөд 17 хувьтай тэнцэж байна. Өөрийн хөрөнгөөр баталгаажсан бондын анхдагч зах зээлийн захиалга өнгөрсөн 11-р сарын 27-ноос эхэлж энэ 12-р сарын 3-ны өдөр хүртэл үргэлжлэх аж. Анхдагч зах зээлийн арилжаа 12-р сарын 3-ны өдрийн 11:00-12:00 цагийн хооронд явагдах бөгөөд захиалгын хуваарилалтыг мөн тухайн өдрийн 17:00 цагт хийх юм.

Дашрамд дурдахад “Минж проперти” компани “Парк таун” бондоо Монголын Үнэт цаасны биржид арилжиж байгаа бөгөөд Монголын Үнэт цаасны биржийн хоёр дахь бүтээгдэхүүн болж байгаа гэдгээрээ онцлогтой юм. Тус бонд нь нэг жилийн хугацаатай, 17 хувийн хүүтэй, хувьцаагаар баталгаажсан, нэг бүр нь 10 мянган төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт нэг тэрбум төгрөг татан төвлөрүүлэх юм.

Орон нутгаас барилгын компани нээлттэй хүрээнд бонд гаргаж байгаа нь хөрөнгийн зах зээлийн түүхэнд анхны тохиолдол болж байна. Үүнийг аймаг, орон нутагт үйл ажиллагаагаа явуулж буй дараа дараагийн компаниуд хөрөнгийн зах зээлд хөл тавих эхлэл гэж шинжээчид үзэж байгаа юм.

Дотоодын хөрөнгийн зах зээлд үүнээс өмнө 15 компани нээлттэй хүрээнд бонд гаргаж, 24.6 тэрбум төгрөгийн санхүүжилт босгосон ба “Парк Таун” бонд 16 дахь нь болж байна. Эдгээрээс “Сүү” компанийн “Сүү бонд” хамгийн өндөр дүнгээр буюу зургаан тэрбум төгрөгийн бонд гаргаж энэ онд эргэн төлөлтөө хийсэн юм. Харин “Монинжбар” ХК-ийн “Бүтээн байгуулалт” бондын эхний транч болон Барилга корпорацийн “Шинэ зуун 210” бонд нэг жилийн 21.6 хувийн хүүтэй байсан нь хамгийн өндөр хүүтэй нээлттэй бондуудад тооцогджээ.

Эх сурвалж: Montsame.mn



ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Махны экспортоос нийтдээ 104.0 сая ам.доллар төвлөрчээ

Манай улс одоогийн байдлаар дэлхийн 8 оронд мах гаргаж байна.

Тодруулбал, энэ оны 11-р сарын байдлаар ОХУ, БНХАУ, Казакстан, Япон, Иран, БНСВУ, Малайз, Хонконгт 955 тонн үхрийн мах, 22,492 тонн адууны мах, 3,814 тонн хонь, ямааны мах, нийт 27,261 тонн мах, дулааны аргаар боловсруулсан 16,027 тонн мах тус тус экспортлоод байна.

Махны экспортоос нийтдээ 104.0 сая ам.доллар төвлөрчээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад махны экспорт 17.7 мянган тонноор, дулааны аргаар боловсруулсан махны экспорт 14.5 мянган тонноор илүү байна. Энэ оны эхний 9 сард 16.7 мянган тонн адууны мах экспортлож байсан бол 11 дүгээр сард 6 тонноор нэмэгджээ. Үүнээс гадна манай улс 815.3 тонн малын дайвар бүтээгдэхүүн экспортлоод байгаа талаар Гаалийн ерөнхий газраас мэдээлэв.

Эх сурвалж: Montsame.mn



“Morgan Stanley” металлургийн нүүрсний ханш 155 ам.доллар болж буурна гэж таамаглав

2018 оны эхний 10 сард БНХАУ нийт 56.9 сая тонн коксжих нүүрс импортолсон нь жилийн өмнөхөөс 1.6 хувиар буурсан дүн боллоо. Зөвхөн 10-р сарын импорт нь 6.08 сая тонн болж жилийн өмнөхөөс 15.7 хувиар өссөн талаар БНХАУ-ын Гаалийн газар мэдээллээ.

Сарын дүнгээрээ энэ оны 7-р сараас хойш БНХАУ-ын коксжих нүүрсний импорт тасралтгүй буурчээ. Хэдий тийм боловч “БНХАУ-ын Засгийн газар тэлэх бодлого баримталж байгаатай уялдаад гангийн гарц өндөр хэвээр байна. Энэ нь БНХАУ-ын импорт буурах төлөвийг улам хойшлуулж байна” гэж “Morgan Stanley” таамаглажээ. Энэ онд металлургийн нүүрсний дундаж ханш 196 ам.доллар байгаа бол ирэх онд 155 ам.доллар хүрнэ гэж тус банк таамагласан байна. Ирэх онд Австралийн металлургийн нүүрсний нийлүүлэлт өсөх төлөвтэй байгааг “Morgan Stanley” мөн онцолжээ. Тухайлбал, “BHP Billiton” компани жилийн нийлүүлэлтээ дөрвөн сая тонноор нэмэхээс гадна “Qcoal” групп “Buegwen” уурхайгаасаа жилд хоёр сая тонн нүүрс нийлүүлэх төлөвтэй байгаа юм байна. Цаашид энэ ордын коксжих нүүрсний олборлолт жилд 10 сая тонн хүрэх боломжтой юм.

Монгол Улсын хувьд оны эхний 10 сард 31.3 сая тонн нүүрс экспортлох нь жилийн өмнөхөөс 10.3 хувиар өсжээ. Ирэх онд 42 сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөж байгаа юм. Сангийн яам 2019 оны төсөвт нэг тонн нүүрсний дундаж ханшийг 75.9 ам.доллараар тооцсон байна. Энэ сард БНХАУ-ын Хөгжил шинэчлэлийн хороо нүүрсний импортоо хязгаарлах шийдвэр гаргасан талаар ойрын эх сурвалж мэдээлсэн юм.

Үүнээс гадна мягмар гарагт Монголбанк бодлогын хүүгээ нэг нэгж хувиар нэмэгдүүлэхдээ “БНХАУ нүүрсний зах зээлдээ хязгаарлалт хийж эхэлсэн нь төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлж, төгрөгийн ханшид дарамт учруулж байна” гэсэн юм. Харин Монголын нүүрс экспортлогч компаниудын тухайд ирэх оны төлөвийг харьцангуй өөдрөгөөр харж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

Aspire Mining: Япон, БНСУ, Энэтхэгийн зах зээлээс хамаарч металлургийн нүүрсний эрэлт өсөх төлөвтэй

Япон, БНСУ-аас гадна Энэтхэгийн зах зээлээс хамаарч металлургийн нүүрсний эрэлт нэмэгдэнэ гэж таамаглаж байгаа талаараа “Aspire Mining” компани танилцууллаа. Тус компанийн хувьд Монгол дахь “Овоот” төслөө онцолж байна.

Жорк стандартаар 247 сая тонн нүүрсний нөөцтэй “Овоот” төслийн урьдчилсан ТЭЗҮ-ийг гаргаад байгаа бөгөөд энэ хүрээнд цаашид төмөр замаар жилд 10 сая тонн нүүрс зах зээлд нийлүүлэх боломжтой гэж үзэж байгаа аж. Монголын нүүрсний ханшийн тухайд Сэхэ боомтод гуравны нэг нь коксжих чанартай нүүрсний ханш 650-700 юань, Ганцмод боомтод угаасан өндөр чанартай коксжих нүүрсний ханш 1,100 юань байна.

Харин Таньшаны боомтод Монголын өндөр чанартай угаасан коксжих нүүрсний ханш 1,515 юаньд хүрсэн бол Австралийнх 1,388 юань байгаа гэсэн тооцоог “Aspire Mining” компани танилцууллаа. ОХУ-ын нутаг дэвсгэрээр дамжин тарифын хөнгөлөлттэйгөөр төмөр замаар нүүрс тээвэрлэх боломжтой болсон нь Монголын коксжих нүүрсэнд шинэ зах зээл бий болгож байна гэж “Aspire Mining” хөрөнгө оруулагчдад хандан гаргасан танилцуулгадаа дурджээ.

Тус компанийн хувьцааг Австралийн Хөрөнгийн биржид 0.019 австрали доллараар арилжаалж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

“Mongolia Energy Corporation”-ийн борлуулалтын орлого 45.7 хувиар өслөө

Хөшөөтийн ордод олборлолт явуулж буй “Mongolia Energy Corporation” 3-9 дүгээр сард 360 сая хонгконг долларын борлуулалтын орлого олсон нь жилийн өмнөхтэй харьцуулахад 45.7 хувиар өссөн дүн боллоо.

Борлуулалт өссөн нь үүнд нөлөөлсөн гэж санхүүгийн тайландаа дурдсан байна. Харин татварын өмнөх алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 21 хувиар өсч, 239.6 сая хонгконг доллар болжээ. Хөшөөтийн уурхай нь Улаанбаатар хотоос баруун зүгт 1,350 км-ийн зайд Ховд аймгийн нутагт байдаг бөгөөд олборлосон нүүрсийг нь Шинжян-Такешиканаар экспортлож байна. Тайлант хугацаанд тус компани 863.7 мянган тонн нүүрс олборлож, 288 мянга гаруй тонн нүүрс борлуулжээ. Борлуулсан цэвэр коксжих нүүрснийх нь дундаж ханш 1,274 хонгконг доллар байсан нь жилийн өмнөхөөс 7.5 хувиар буурсан байна. Мөн эрчим хүчний нүүрснийх нь дундаж ханш 71.5 хонгконг доллар байсан нь жилийн өмнөхтэй харьцуулахад 24 хувиар буурчээ.

Хонгконгийн Хөрөнгийн биржид “Mongolia Energy Corporation”-ийн хувьцааны ханш хамгийн сүүлд 0.13 хонгконг доллар болсон байна. 2018 он гарснаас хойш хувьцаа нь 31.5 хувиар буурчээ.

Эх сурвалж: BloombergTv.mn



БУСАД МЭДЭЭ

Мөнгөний бодлогын хүүг нэг нэгж хувиар өсгөж, 11 хувьд хүргэлээ

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2018 оны 11-р сарын 27-ны ээлжит бус хурлаар Бодлогын хүүг 1 нэгж хувиар өсгөн 11 хувьд хүргэх шийдвэр гаргалаа.

Хэрэглээний үнийн индексээр хэмжигдсэн жилийн инфляци 2018 оны 10-р сарын байдлаар улсын хэмжээнд 6.3 хувь, Улаанбаатар хотод 6.8 хувьтай байна. Хэдийгээр түүхий эдийн үнэ харьцангуй өндөр түвшинд хадгалагдаж, эдийн засаг энэ оны 3-р улиралд хүлээлтээс давж 6.7 хувиар өссөн боловч эдийн засгийн гадаад орчны тодорхой бус байдал өндөр байна.

Ирэх оны төсвийн алдагдал харьцангуй өндөр түвшинд батлагдсан, АНУ-ын Холбооны нөөцийн банк мөнгөний бодлогын суурь хүүгээ нэмэгдүүлсэн, БНХАУ нүүрсний зах зээлдээ хязгаарлалт хийж эхэлсэн зэрэг нь төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлж төгрөгийн ханшинд дарамт учруулж байна. Иймд, Монголбанк нэг талаас эдийн засгийн идэвхжилийг дунд хугацаанд зохистой түвшинд хадгалах, нөгөө талаас гадаад зах зээлийн тодорхой бус байдлыг харгалзан үзэж Мөнгөний бодлогын хорооны ээлжит бус хурлаар бодлогын хүүг нэмэгдүүлэх шийдвэр гаргалаа.

Монголбанкны энэ удаагийн шийдвэр нь инфляцийг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах зорилттой нийцтэй бөгөөд төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэн, үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх итгэлийг хамгаалж, макро эдийн засгийн дунд хугацааны тогтвортой байдлыг хадгалахад чиглэж байна.

Монголбанкнаас 2018 оны 12-р сараас эхлэн Төв банкны 28 долоо хоногийн хугацаатай үнэт цаас арилжаалах шийдвэр гаргалаа.

Эх сурвалж: Монголбанк

Цахим гүйлгээний дүнгийн дээд хязгаарыг 3 сая төгрөг болгож нэмэв

Үндэсний цахим гүйлгээний төвийн системээр 7 хоногийн 24 цагаар дамжих гүйлгээний дүнгийн дээд хязгаар 1 сая төгрөг байсныг 3 сая төгрөг болгон нэмэв. Ингэснээр 3 сая хүртэлх төгрөгийн банк хооронд хийх төлбөрийг өдөр бүр 24 цагийн турш тасралтгүй, түргэн шуурхай гүйцэтгэх боломжтой болж байгаа бөгөөд 3 хүртэлх сая төгрөгийн төлбөрийг байршил, өдөр хамааралгүй аль ч цагт 1-4 секундэд гүйцэтгэх бүрэн боломжтой болж байна. Үүгээр Монгол Улсад цахим төлбөр тооцоо гүйцэтгэх үйл ажиллагаа дахин нэг шат ахиж, эдийн засаг дахь мөнгөний эргэлтийг хурдасгах чухал ач холбогдолтой. Иргэд болон банкуудаас ирүүлсэн хүсэлтийг сайтар судалж, холбогдох судалгаа тооцооллыг хийсний үндсэн дээр энэхүү шийдвэрийг гаргасан бөгөөд цахим төлбөр тооцоог нийтийн хэрэглээ болгож хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлж буй юм.

Эх сурвалж: Montsame.mn



АХБ: Монгол Улс эдийн засгаа төрөлжүүлэхэд хугацаа хэрэгтэй

“Төгрөгийн ханшийг тогтвортой барих гэж валютын нөөцөө хэт их зарцуулах нь оновчтой бодлого биш” гэж Азийн Хөгжлийн банкны шинжээчид онцоллоо. 2018 он гарснаас хойш төгрөгийн ханш ам.долларын эсрэг 7.4 хувь сулраад байна. Гэхдээ инфляцын түвшин 6.3 хувьтай байгаа үед энэ нь хүлээн зөвшөөрөгдөх хэмжээ гэж Азийн Хөгжлийн банкны шинжээчид үзэж байгаа юм.

Монголбанк он гарснаас хойш 979 сая ам.долларын интервенц хийгээд байгаа аж. Энэ ондоо нэг тэрбум гаруй ам.долларын интервенц хийх төлөвтэй байгааг Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баярсайхан онцолж байсан юм. Хэдий тийм боловч Олон Улсын Валютын Сангийн зургаа дахь шатны үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлтэд гадаад валютын нөөцөд эмзэг байдал оршоор байгааг анхаарууллаа. Мөн дотоодын эрэлт нэмэгдсэнээр урсгал дансны алдагдал үргэлжлэн өсөх төлөвтэй байгаа учраас Монголбанкийг Мөнгөний бодлогоо чангаруулж, зээлийн өсөлтийг хязгаарлах зөвлөмж өгөөд байна.

“Монгол Улсын экспортын бүтээгдэхүүн болон зах зээл хэт төвлөрсөн байна” гэж Азийн Хөгжлийн банкны ахлах эдийн засагч Деклан Магий онцоллоо. Эдийн засгийн төрөлжилт болон орлого эерэг хамааралтай байдаг тул эдийн засгийг төрөлжүүлэх шаардлагатай байгаа гэж дүгнэсэн юм. Мөн “Байгалийн баялагтай орнууд эдийн засгаа төрөлжүүлэх нь гадаад худалдааны нөхцөлийн шокноос үүдэх сөрөг нөлөөллийг арилгахад чухал үүрэгтэй” гэж тэрбээр мэдээллээ.

Оны эхний 10 сарын байдлаар экспортын бүтээгдэхүүний 86 хувийг эрдэс бүтээгдэхүүний экспорт эзэлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс долоо орчим пунктээр өссөн үзүүлэлт юм. Сүүлийн жилүүдэд экспортын орлогод эрдэс бүтээгдэхүүний эзлэх хувь өсөх хандлагатай байна. Үүнийг дагаад төсвийн орлогын бүрдэлтэд уул уурхайгаас орж ирэх орлогын хэмжээ өсөж байгаа аж. Тухайлбал, 2019 оны төсвөөс харахад уул уурхайн орлого төсвийн орлогын 27 хувийг дангаараа бүрдүүлэхээр байгаа нь энэ оны батлагдсан түвшнээс таван нэгж хувиар өндөр үзүүлэлт юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.